

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 08 өдөр

Дугаар: 20

Улаанбаатар хот

Баримт бичигт нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 1.2.1-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 3.1.1 дэх заалтын “А.Үндэсний давхар даатгал ХК-д ашиглагдах нийт дансны үндсэн ангилал” хэсгийн жагсаалтад “35” кодтой, “Учирч болзошгүй хохирлын нөөц сан” гэж нэмсүгэй.

2. Мөн баримт бичгийн 3.2.2 дахь заалтын “Бүртгэл” хэсгийн “10.Найдваргүй авлагын бүртгэл”-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“Бизнесийн үйл ажиллагааны явцад авлагын зарим хэсэг төлөгдөх эсэх нь эргэлзээтэй болох, яваандаа найдваргүй болж данснаас хасагдах явдал гардаг.

Авлага нь нэхэмжлэх эзэнгүй болох, төлбөр хариуцагч нас барах, дампуурах зэрэгт найдваргүйд тооцогдож данснаас хасагдана. Төлөгдөх найдваргүй болох нь тогтоогдсон авлагыг хөрөнгөнөөс хасах ба найдваргүй авлагын зардлыг бүртгэх шууд данснаас хасах болон нөөцийн гэсэн аргууд байдаг.

Үндэсний давхар даатгал ХК-н хувьд авлагыг:

1. Даатгалын хураамжийн авлага
2. Бусад авлага гэж үндсэн хоёр хэсэгт ангилна.

Даатгалын хураамжийн авлага хугацаа хэтэрсэн, төлөгдөхгүй нь тодорхой болсон үед Эрсдэлийн хорооны шийдвэрийг үндэслэн Даатгалын хураамжийн буцаалт гэсэн данс руу хааж өгөх ба энэхүү авлагын хувьд Найдваргүй авлагын нөөц сан байгуулах шаардлагагүй юм.

Бусад авлагын хувьд компани нь тайлант хугацаа бүрийн эцэст ирээдүйд найдваргүй болж болзошгүй авлагын хэмжээг урьдчилан тооцож найдваргүй авлагын нөөц байгуулан бүртгэх нь зүйтэй.

Найдваргүй авлагын нөөцийг дор дурьдсан хувиар авлагын данс бүрээр байгуулж бүртгэнэ. Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьд найдваргүй авлагын нөөц санг байгуулахдаа авлага анх үүссэнээс хойш 6 сарын дараагаас 180 хоногоос 25%-иар, 9 сарын дараа 50%-иар, 12 сарын дараа 75%-иар, 15 сарын дараа 100%-иар тооцож данс бүрээр бүртгэнэ”

3. Мөн баримт бичгийн 3.2.7 дахь заалтын “Хэмжилт ба үнэлгээ” хэсгийн программ хангамжийн хорогдуулалт тооцох хугацаа (жилээр)-г “3” гэснийг “2” гэж өөрчилсүгэй.

4. Мөн баримт бичгийн 3.3.3 дахь заалтын "Тодорхойлолт" хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"Үндэсний давхар даатгал ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан давхар даатгалын компанийн нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын дагуу дараах нөөц сангуудыг даатгалын төрөл хэлбэр тус бүрээр нь байгуулна. Үүнд:

- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан;
- Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан;
- Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан;
- Учирч болзошгүй хохирлын нөөц сан;
- Алдагдлаас хамгаалах сан.

МИД-н бүтээгдэхүүний хувьд:

- Хамтын эрсдэлийн нөөц сан;
- Дунд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сан;
- Дээд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сан.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан гэдэгт даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсгийг ойлгоно. Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьд МИД-н хураамжийн орлогоос бусад бүх хэлбэрийн даатгалын хураамжийн орлогоос хувь тэнцүүлэх аргаар Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг байгуулна.

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС буюу англиар Incurred but not reported-IBNR) гэдэгт тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС буюу англиар Reported but not Paid-RBNP) гэдэгт даатгалын тохиолдол болсон тухай даатгагч мэдсэн боловч төлөөгүй байгаа нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.

Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС буюу англиар Unexpired risk reserve-URR) гэдэг нь даатгагчийн хүчин төгөлдөр гэрээтэй холбогдон тайлант хугацаанаас хойш гарах нийт нөхөн төлбөр ба зардлын орлогод тооцоогүй хураамжаас давсан хэсгийг нөхөн төлөх даатгагчийн хүлээх хариуцлагын дүнг ойлгоно.

Алдагдлаас хамгаалах нөөц сан гэдэг нь давхар даатгагч даатгалын хохирлыг нөхөн төлөх нөөц сан хүрэлцэхгүй болсон тохиолдолд ашиглах зориулалт бүхий санг ойлгоно. Тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан тусгай нөөц сан юм.

Хамтын эрсдэлийн нөөц сан нь даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн төлөх (Малын индексжүүлсэн даатгалд) үүргийг хамтран хариуцахаар хэд хэдэн даатгагчид (Даатгалын компаниуд) хамтран хуулийн дагуу байгуулсан сан.


Дунд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сан нь давхар даатгалын компанийн хувьд нөхөн төлбөр төлөхөөр зориулагдсан үндсэн нөхөн төлбөрийн нөөц сан юм. МИД-н хувьд нөхөн төлбөрт Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулсны дараа эрсдэлийн дунд түвшинд нөхөн төлбөрийн үлдэгдлийг санхүүжүүлэх зориулалттай сан.

Дээд түвшний эрсдэлээс хамгаалах нөөц сан нь МИД-н бүтээгдэхүүний хувьд нөхөн төлбөрт эрсдэлийн дунд түвшинд нөхөн төлбөрийн үлдэгдэл гарвал санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан нөөц сан юм"

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ